

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1 Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23
5. Аудитын хураангуй тайлангийн хавсралт	24

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Л.ЦЭДЭВСҮРЭН ТАНАА

2020.02.21 № 06/603
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны санхүүгийн тайланд дараах зөрчил илэрсэн. Үүнд:


1. Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн 673,761.8 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл, зарцуулалтын тайланд хяналт хэрэгжүүлээгүй,
2. Тайлант хугацааны 797,498.6 мянган төгрөгийн гүйлгээний баримтыг аудитад ирүүлээгүй,
3. Тайлант онд 383,607.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсныг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй,
4. Анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, бараа, ажил үйлчилгээ хүлээн авсан нь баримтаар нотлогдоогүй 137,538.6 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэсэн,
5. Түлш, шатахууны 45,351.5 мянган төгрөгийн тайлан бэлтгээгүй, шатахуун талон, шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүйгээр бөөн дүнгээр бүртгэсэн зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх, ангилал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Цэдэвсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, үндсэн хөрөнгө, бараа материалын тайлан бэлтгэж, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгах, төсвийн эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний холбогдох заалтыг мөрдөж ажиллах талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 10-наас 2020 оны 02 дугаар сарын 19-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Ц.Энхжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталгаажуулан ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсрол, соёл, шинжлэх ухаан, биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт, тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар оюуны өндөр боловсрол, ёс суртахууны төлөвшилтэй, эрүүл чийрэг, өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэхэд оршино.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлого зохицуулах, хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус яам нь БСШУСС-ын 2017 оны А/40 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг бөгөөд Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжийн өөрчлөлтийг мөрдөн ажиллаж байна.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн Acolous программ хангамж ашигладаг байна.

Тус сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 12 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,726,116.1 мянган төгрөгөөс тооцон 57,261.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тогтоохдоо материаллаг байдлын хувь хэмжээг өөрчлөөгүйгээр тайлант үеийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сууриар сонгон 93,050.0 мянган төгрөгөөр тогтоов. Тайлант хугацаанд засгийн газрын нөөц сангаас 3,602,924.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авч зарцуулсантай холбоотойгоор материаллаг байдлыг 35,788.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,277,311.9 мянган төгрөгөөр буюу 10.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мянган төгрөг/
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	167,974.9	666,128.2	498,153.4
Авлага	85,608.0	608,968.9	523,360.9
Урьдчилгаа	7,770.0	0.0	-7,770.0
Бараа материал	74,596.9	57,159.4	-17,437.5
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	11,814,777.8	10,039,312.5	-1,775,465.3
Үндсэн хөрөнгө	11,814,777.8	10,039,312.5	-1,775,465.3
Биет хөрөнгө	7,392,007.8	6,126,842.3	-1,265,165.6
Биет бус хөрөнгө	4,422,770.0	3,912,470.3	-510,299.7
Нийт хөрөнгийн дүн	11,982,752.7	10,705,440.8	-1,277,311.9
Нийт өр төлбөр	70,084.2	383,607.4	313,523.3
Богино хугацаат өр төлбөр	70,084.2	383,607.4	313,523.3
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,912,668.5	10,321,833.3	-1,590,835.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,912,668.5	10,321,833.3	-1,590,835.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,982,752.7	10,705,440.8	-1,277,311.9

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 711.3 хувь буюу 523,360.9 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнээс нэр дансны зөрүү үүсэж буцаагдсан 358,974.3 мянга, төслийн санхүүжилт 249,863.4 мянга, ажиллагчидтай холбоотой 131.2 мянган төгрөг байна. Авлагын 99.9 хувь буюу 608,701.6 мянган төгрөгийг нэмэлт төсвийн данснаас төвлөрүүлсэн татаас санхүүжилтийн авлага байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,775,465.3 мянган төгрөг буюу 15.0 хувиар буурахад тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн зардал голлон нөлөөлсөн байна. Тус яам нь БСШУСС-ын багцаас үнэ төлбөргүйгээр 650,181.5 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг шилжүүлэн авч, биет хөрөнгөд 1,915,347.0 мянган төгрөгийн, биет бус хөрөнгөд 510,299.8 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 313,523.3 мянган төгрөг буюу 547.4 хувиар өссөн байна. Энэ нь 358,974.3 мянган төгрөгийн нэр данс зөрүүтэй гүйлгээ буцсанаас оны эцэст үлдэгдэлтэй гарч өр төлбөр өсөхөд нөлөөлжээ. Бусад 24,633.1 мянган төгрөгийн өр төлбөрөөс 18,754.7 мянган төгрөг ажиллагчидтай холбоотой өглөг, 5,878.4 мянган төгрөг байгууллагуудад төлөх өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 10,321,833.3 мянган төгрөг болж 1,590,835.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд санхүүгийн үр дүн 1,615,340.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны

залруулгын 24,505.3 мянган төгрөгийн бичилт нь өмнөх оны авлага, өглөг, бусад тооцоонуудтай холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь тайлант онд 6,500.0 мянган төгрөгийн орлого батлагдсанаас гүйцэтгэлээр 20,673.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 318.1 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
			Зөрүү	Хувь
Лавлагааны хураамж	6,500.0	7,718.5	-1,218.5	118.7
Бүртгэлийн хураамж	0.0	12,954.8	-12,954.3	0.0
Нийт дүн	6,500.0	20,673.3	-14,173.3	318.1

Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 14,173.3 мянган төгрөгөөр давсан нь засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо өсөж, бүртгэлийн хураамжийн орлого нэмэгдэхэд голлон нөлөөлсөн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 2,859,056.4 мянган төгрөгийн төсвийг урсгал зардлыг санхүүжүүлэхээр баталжээ. Нийт зардлын 2,852,556.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 6,500.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөн, улсын төсвөөс 2,834,075.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн үйл ажиллагаанаас 7,559.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 2,831,809.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулж үлдэгдэл 9,825.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардал 2,831,809.9 мянган төгрөг буюу 99.0 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь урсгал шилжүүлэг 23,480.6 мянга, бараа, ажил үйлчилгээний зардлаас 3,765.9 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Тус яам нь нийт 4,301,144.9 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна. Үүнд: засгийн газрын нөөц хөрөнгөөс 3,602,924.5 мянга, UNDP, Unisef, НҮБ-ийн хүүхдийн сангаас 269,777.0 мянга, Боловсролын чанарын шинэчлэл төслөөс 359,186.5 мянга, 2018 оны үлдэгдэл, давсан орлого, бүртгэлийн хураамжийн 69,256.9 мянган төгрөг байна. Нэмэлт төсвийн данснаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид 153,370.5 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 3,602,924.5 мянга, урсгал шилжүүлэгт 294,986.5 мянга, нийт 4,051,281.5 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 249,863.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 14 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,783,238.4 мянган төгрөгийн 10 алдаа, зөрчил илэрснээс 1,155,521.1 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 627,717.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн. Үүнд:

1. Нийт ажил гүйлгээний 45.4 хувь буюу 3,389,522.9 мянган төгрөгийн баримтыг түүвэрлэн шалгахад 1,045,837.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн 673,761.8 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэл, зарцуулалтын тайланд хяналт хэрэгжүүлээгүй,

- Анхан шатны баримт бүрдэл хангалтгүй, бараа, ажил үйлчилгээ хүлээн авсан баримтаар нотлогдоогүй 137,538.6 мянга,
- Ажил гүйлгээг шууд зардалд бүртгэсэн 210,183.7 мянга,
- Эдийн засгийн зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулсан 24,353.2 мянган төгрөгийн ажил гүйлгээ байна.

Тайлант хугацааны 797,498.6 мянган төгрөгийн гүйлгээний баримтыг аудитад ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "... Энэ хуулийн 15.1-д заасан байгууллага, албан тушаалтан төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг хугацаанд нь саадгүй гаргаж өгөх үүрэгтэй", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-д "Төсвийн ерөнхийлөн захирагч нь Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр тухайн салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина.", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө", 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 5-д "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.", Сангийн сайдын 2014 оны 5 тоот тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх, үнэн зөв байх, иж бүрэн байх, ангилал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын байгууллагаас шаардсан мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх, ажил гүйлгээг анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийг зарлагын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, бүртгэх, тайлагнах, ажил гүйлгээг шууд зардалд бүртгэхгүй байх, Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төсөл арга, хэмжээнд хяналт тавих, дотоод хяналтыг сайжруулах талаар албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгөтэй холбоотой 64,332.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл, кассын үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй,
- Төрийн сангийн данснаас арилжааны банкаар дамжуулан 52,953.8 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн. Үүнээс 51,453.8 мянган төгрөгийн гүйлгээний кассын тайлан бэлтгээгүй,
- Хураамжийн орлого 2,834.5 мянган төгрөгийг орлогын баримт бичээгүйгээр хураан авсан, кассын тайлан бэлтгээгүй, хураан авсан орлогыг төрийн сангийн банканд тухай бүр тушаагаагүй,
- Арилжааны банкны төлбөрийн картын данснаас арга хэмжээний зардалд нийт 10,044.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.5-д "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.2, 3.1, 3.9, 7.2-т заасныг мөрдөөгүй, иж бүрэн байх, тохиолдсон байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулах, байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллах талаар албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайлант хугацаанд нягтлан бодогч нь түлш, шатахуун, автомашины урсгал засварын зардалд бүртгэлээр хяналт тавиагүй байна. Үүнд:

- Түлш, шатахууны 45,351.5 мянган төгрөгийн тайлан бэлтгээгүй,
- Шатахуун талон, шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүйгээр бөөн дүнгээр бүртгэсэн, /аудитын явцад шатахууны картын дансны хуулгыг гаргаж өгөөгүйгээс үлдэгдлийг тулган баталгаажуулаагүй болно/
- Жолоочийн тооцооны хуудсыг тухай бүр гарын үсэг зурж баталгаажуулаагүй,
- Бусдын автомашинд урсгал засвар хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "... анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.3-д "... нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, ... баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шатахуун зарцуулалтын тооцоо хийх, тайлан бэлтгэх, жолоочийн тооцооны хуудсыг хөтөлж хэвших, автомашины урсгал засварын зардалд бүртгэлээр хяналт тавих талаар албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд баталгаажуулж ирүүлээгүй, санхүүгийн тайлангийн тодруулгыг бүрэн бэлтгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д "... жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, ...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга.", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан Санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын "Санхүүгийн тайлангийн тодруулгыг бэлтгэх үлгэрчилсэн загвар"-тай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлангийн тодруулгыг бүрэн бэлтгэх, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлэх талаар албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар илэрсэн 627,717.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитаар санхүүгийн тайлан, баримт материалуудыг хугацаандаа ирүүлээгүйгээс дараах асуудлуудад нарийвчилсан горим сорил хэрэгжүүлээгүй тул доорх асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

1. Цалингийн нэмэгдлийн тооцооллыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу олгож байгааг нягтлах, цагийн бүртгэлтэй тулган давтан тооцоолох;
2. Үндсэн болон туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогын зарцуулалтыг хянах;
3. Нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулж байгаа ажил гүйлгээнд хяналтын горим хэрэгжүүлэх;
4. Хөрөнгийн дансанд биет горим хэрэгжүүлэх, үндсэн хөрөнгийн элэгдлийг холбогдох журмын дагуу тооцоолсон эсэхийг давтан гүйцэтгэх шаардлагатай байна.

Мөн хөрөнгийн тооллогыг чанартай хийж, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгах, хөрөнгийн нэр төрөл, тоо ширхэг, ангиллыг зөв бүртгэх, хөрөнгийг коджуулах, төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд дотоод аудитын нэгж хяналт хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах нь зүйтэй байна.

Ажил олгогчийн буруугаас ажлаас чөлөөлөгдсөн 6 ажилтанд шүүхийн шийдвэрээр 29,096.1 мянган төгрөгийн нөхөн олговор олгосныг буруутай албан тушаалтнаар төлүүлэх албан шаардлагыг дээд шатны төсөв захирагчийн дотоод аудитын нэгжид хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 38 мэдээллийг хугацаанд нь байршуулан, 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 605,522.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 465,467.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 140,055.3 мянган төгрөгийн 3 зөвлөмж өгсөн байна.

Өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, тооллогоор дутсан 139,596.0 мянган төгрөгийн хөрөнгийн эзэн холбогдогчийг тогтоож, нөхөн төлүүлэх, шатахуун зарцуулалтын тайлан бэлтгэх 2 албан шаардлага өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Мөн анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах, ажил гүйлгээг шууд зардалд бүртгэхгүй байх, тус яамны байранд үйл ажиллагаа явуулдаг кофе шоптой гэрээ байгуулах 2 зөвлөмж хэрэгжээгүй байна.

Өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

“Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэлийг Аудитын гэрчилгээний аудитын гол асуудал хэсэгт тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Балансын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 383,607.4 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй гарсныг тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Өглөг баталгаажихгүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Өглөгийг тооцоо нийлж, актаар баталгаажуулах;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө, бараа материалын тайлан бэлтгээгүй, тооллогын үр дүнг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, ...", 73 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь ... тооллогын акт батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана", Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын хавсралтаар баталсан анхан шатны бүртгэлийн маягтай тус тус нийцэхгүй, санхүүгийн

тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн байх үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2 Эрсдэл:

Тооллого үр дүнгүй байх, хөрөнгө биетээр оршихгүй байх.

2.3 Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайлан бэлтгэх, хөрөнгийн тооллогыг хуулиар тогтоосон хугацаанд чанартай хийж, тооллогын дүнг хэлэлцэж санхүүгийн тайланд тусгах;

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3 Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Санхүүгийн тайлагналтай холбоотой 120,999.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Үүнд:

- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн санхүүжилтийн дүн төрийн сангийн дансны хуулгын дүнгээс 58,493.3 мянга, мөнгөн гүйлгээний журналаас 43,702.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн,
- Санхүүгийн тайлангийн бараа материал, өглөгийн дүн ерөнхий дэвтрийн дүнгээс 18,803.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн,
- Өмнөх оны хуримтлагдсан ашиг руу анхан шатны баримтгүйгээр 71,233.0 мянган төгрөгийг бүртгэсэн. Үүнд: өмнөх оны өглөгийн үлдэгдэл 34,299.2 мянга, авлагын үлдэгдэл 17,690.4 мянга, хөтөлбөр арга хэмжээний зардал 1,318.0 мянга, цалинтай холбоотой 5,592.9 мянга, бусад 12,332.5 мянган төгрөг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-д "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-д "бүх өр төлбөр", 14.4.5-д "бүх орлого", 14.4.6-д "бүх зардал" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх, тасалбар болголт байх, ангилал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан, цэвэр өмчийн дүн буруу илэрхийлэгдэх, авлага, өглөгийг барагдуулахгүй байх.

3.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг үнэн зөв бүртгэх, өмнөх оны хуримтлагдсан ашиг руу бүртгэсэн ажил гүйлгээг нягтлан залруулах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

4 Дотоод хяналттай холбоотой асуудал

4.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд бага үнэтэй түргэн элэгдэх зүйл, бараа ажил үйлчилгээ, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас хүүхдийн баярын арга хэмжээнд 16,619.2 мянга, гадаад арга хэмжээ, бэлэг дурсгалд 14,928.0 мянга, уулзалт ярилцлагын зардалд 7,475.0 мянга, шагнал урамшуулалд 10,000.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2014 оны 5 тоот тушаалын 6 дугаар хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-тай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэн зөв байх, ангилал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

4.2 Эрсдэл:

Төсвөөс үргүй зардал гарах, төсвийн эдийн засгийн ангилал зөрчигдөх.

4.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг мөрдөж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

5 *Дотоод хяналттай холбоотой асуудал*

5.1 Илрүүлэлт:

Авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Санхүүгийн тайланд бүртгэлтэй УНА6103 улсын дугаартай Hyundai Sonota маркийн автомашины гэрчилгээ Сүхбаатар дүүргийн хөдөлмөрийн хэлтсийн нэр дээр бүртгэлтэй,
- УНУ9906 улсын дугаартай 5800 хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжтай NISSAN Patrol маркийн автомашиныг хот дотор өдөр тутмын хэрэглээнд ашиглаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "... анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 4.1-д "... заасан албан тушаалтан хөдөө ажлын зориулалтаар хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 3501-4700 см3 автомашинтай байхыг зөвшөөрч, ...", 8-д "Төсвөөс санхүүждэг байгууллага хот дотор ажил, үйлчилгээнд хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж нь 2500 см3-ээс дээш, туулах чадвар өндөртэй, шатахуун их зарцуулдаг автомашин хэрэглэх, ... тус тус хориглосугай" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

5.2 Эрсдэл:

Хөрөнгө баталгаажихгүй байх, Засгийн газрын тогтоол зөрчигдөх, төсвөөс үргүй зардал гарах.

5.3 Өгсөн зөвлөмж:

Hyundai Sonota маркийн автомашины гэрчилгээг байгууллагын нэр дээр бүртгүүлэх, Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах;

5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

6 *Орлого төвлөрүүлэхтэй холбоотой асуудал*

6.1 Илрүүлэлт:

Бүртгэлийн хураамжийн 11,12 дугаар сарын орлого 2,855.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4-д "Туслах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг төсвийн жилийн дундуур авсан бол түүний төсвийг нэмэлт төсөв хэлбэрээр, бусад тохиолдолд тухайн жилийн төсөвт тусган хэрэгжүүлнэ", 47 дугаар зүйлийн 47.1.5-д "төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого" гэж заасантай нийцэхгүй байна.

6.2 Эрсдэл:

Орлогыг хяналтгүйгээр зарцуулах.

6.3 Өгсөн зөвлөмж:

Бүртгэлийн хураамжийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлэхгүй байх

6.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	168,049,358.99	666,128,249.00
33	АВЛАГА	85,682,486.99	608,968,895.00
33100	Ажиллагчидтай холбоотой авлага	00.00	131,247.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	62,710,636.99	608,837,648.00
335	Бусад авлага	22,971,850.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	22,971,850.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	7,770,000.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	7,770,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	74,596,872.00	57,159,354.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	9,820,000.00	9,820,000.00
354	Хангамжийн материал	64,776,872.00	47,339,354.00
35410	Бичиг хэргийн материал	5,629,060.00	2,266,270.00
35420	Аж ахуйн материал	19,651,612.00	11,514,204.00
35430	Сэлбэг хэрэгсэл	3,646,000.00	3,738,000.00
35440	Түлш шатах тослох материал	7,180,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	28,670,200.00	29,820,880.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,814,777,779.34	10,039,312,516.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,814,777,779.34	10,039,312,516.37
392	Биет хөрөнгө	7,392,007,824.35	6,126,842,256.69
39203	Авто-тээврийн хэрэгсэл	420,282,850.00	420,282,850.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-386,341,958.73	-386,341,958.73
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	10,291,505,565.68	10,864,454,557.48
39206	Хуримтлагдсан элэгдэл	-3,248,310,051.59	-5,112,554,933.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	597,945,032.26	675,177,494.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-283,073,613.27	-334,175,752.63
393	Биет бус хөрөнгө	4,422,769,954.99	3,912,470,259.68
39301	Программ хангамж	5,068,145,178.32	5,068,145,178.32
	Хасагдуулга	-645,375,223.33	-1,155,674,918.64
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,982,827,138.33	10,705,440,765.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	70,084,160.59	383,607,441.95
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	70,084,160.59	383,607,441.95
413	Өглөг	70,084,160.59	383,607,441.95
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	56,163,491.63	18,754,697.54
	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,891,370.00	00.00
4136	Бусад өглөг	9,029,298.96	364,852,744.41
41361	Байгууллагад төлөх өглөг	9,029,298.96	364,852,744.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,912,742,977.74	10,321,833,323.42
51	Засгийн газрын хувь оролцоо	11,912,742,977.74	10,321,833,323.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,135,349,477.27	1,135,349,477.27
51101	Өмч: - төрийн	1,135,349,477.27	1,135,349,477.27
512	Хуримтлагдсан үр дүн	10,777,393,500.47	9,186,483,846.15
51210	Өмнөх үеийн үр дүн	13,568,636,132.02	10,801,824,371.37
51220	Тайлант үеийн үр дүн	-2,791,242,631.55	-1,615,340,525.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,982,827,138.33	10,705,440,765.37

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,928,887,677.99	7,689,663,256.54
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	62,042,370.00	652,731,533.55
120	Нийтлэг татварын бус орлого	62,042,370.00	652,731,533.55
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	62,042,370.00	2,550,080.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,042,370.00	2,550,080.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	650,181,453.55
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,866,845,307.99	7,036,931,722.99
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,278,241,700.00	2,834,075,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,278,241,700.00	2,834,075,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	588,603,607.99	4,202,733,867.99
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	588,603,607.99	586,695,386.99
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	3,602,924,481.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	13,114,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	00.00	122,055.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	122,055.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,720,130,309.54	9,305,003,781.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,720,130,309.54	9,305,003,781.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,560,623,192.69	9,174,253,541.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,533,379,063.45	1,884,589,641.55
210101	Үндсэн цалин	1,131,513,362.38	1,351,693,648.27
210102	Нэмэгдэл цалин	116,445,500.00	291,602,095.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	93,597,101.43	70,842,777.64
210104	Урамшуулал	191,823,099.64	170,451,120.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,109,496.99	232,133,159.30
